

# COVID-19 халдвартай иргэдийг тусгаарлан эмчлэх түр эмнэлэгт хэрэгжүүлэх хяналт,

## ЭМЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

Халдвар хамгааллын дэглэм мөрдөн ажилла

### Хүчилтөрөгчийн ханамж(SpO2)-ийг хяна!

#### Пульсоксиметерээр:

- Хумсны будгыг арилга
- Пульсоксиметрээ асаа
- Хөдөлгөөнгүй байх үед мэдрэгчийг гарын эсвэл хөлний хуруунд углаж, чимхүүлж тогтооно.
- Пульсийн дохио тогтвортой орж иртэл 20-30 секунд хүлээ
- Нэмэлтээр амьсгалуулж буй хүчилтөрөгчийн хэмжээг нэмэгдүүлэх буюу бууруулснаас хойш SpO2-ийг 2-3 минутын дараа дахин шалгаж, цаашид дахин 15 минутыг дотор шалгаж хяналтын хүснэгтэнд тэмдэглэнэ.



### SpO2-хүчилтөрөгчийн ханамжийн тухай ойлголт:

- Судасны лугшилтын тоо (PR) бус харин SpO2-ийн хувь хэмжээг уншина гэдгээ анхаар!
- **SpO2 < 90%** (жирэмсэн эх < 94% эсвэл ABCD-ийн яаралтай шинж тэмдэг илэрсэн) бол:

### Нэмэлт хүчилтөрөгчөөр амьсгалуулах:

Хүчилтөрөгчийг шатлан нэмэгдүүлэх нь **НӨӨЦИЙГ ХЭМНЭНЭ.**

Ац гуурсны сэртэнг хамрын нүхэнд байрлуул. Гуурсны бугуйлыг чихэнд өлгөнө. O2-ийн урсгалын хурд > 5л байвал нь хамрын салст хатаах сөрөг нөлөөтэй.



Хүчилтөрөгчийг **5л/мин** эхлүүл  
Хамрын ац гуурс ашиглана.  
Хариу урвалыг үнэлнэ.

Хямрал үргэлжилсэн эсвэл SpO2 < 90% (жирэмсэн бол < 94% эсвэл ABCD-ийн яаралтай шинж тэмдэг илэрсэн байвал)

Нүүрний маскийг хамар амны дээгүүр нягт байрлуулж бэхэлнэ. Бэхлэгч оосрыг толгойг давуулан татаж чангална.



Нүүрний маск ашиглана.  
Хүчилтөрөгчийг **6-10л/мин** болгож өсгөнө. Үр дүнг үнэлнэ.

Хямрал үргэлжилсэн эсвэл SpO2 < 90% (жирэмсэн бол < 94% эсвэл ABCD-ийн яаралтай шинж тэмдэг илэрсэн байвал)

Хүчилтөрөгчийн хэмжээг хангалттай нэмэгдүүлэхийн тулд нөөцлүүр уутыг дүүрэн байлгахад анхаарна.



Нөөцлүүр ууттай нүүрний маск **10-15 л/мин**, нөөцлүүр уутыг дүүрэн байлгахад анхаарна. Ухаан санааны байдлыг хянах, шаардлагатай бол тусламж дуудна.

Хямрал үргэлжилсэн эсвэл SpO2 < 90% (жирэмсэн бол < 94% эсвэл ABCD-ийн яаралтай шинж тэмдэг илэрсэн байвал)



O2-ийн хэрэгцээ нэмэгдэх нь дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх заалт мөн. Боломжтой бол **CPAP, BiPAP** эсвэл **HFNO** арга хэрэглэж O2 хангамж хангалттай байлгах.

### Дэмжих эмчилгээ хийх:

- **Дексаметазон:** 6 мг-аар уух эсвэл судсаар (IV) тарих, 7-10 хоног (эсвэл гидрокортизон 50 мг-аар 8 цагаар, эсвэл преднизолон 40 мг-аар өдөр бүр, эсвэл преднизолон 16 мг-аар 12 цагаар)
- Шингэн сайн уух & тэжээллэг хоол идэх
- Хяхнасан амьсгалтай бол **сальбутамол**,
- Халуурсан бол **парацетамол** уулгана.
- Өвчтөнийг **түрүүлгэн** харуулж хэвтүүлэх, баруун зүүн хажуугаар харуулж хэвтүүлэх, босгож суулгах болон боломжтой бол орноос босгох


**Түрүүлгэн харуулж хэвтүүлэх**  
30 минут –2 цаг:



**Баруун хажуугаар**  
30 минут –2 цаг:  
Зүүн талдаа хэвтэх



**Зүүн хажуугаар**  
30 минут –2 цаг:  
Баруун талдаа хэвтэх



**45 градус налж суух**  
30 минут –2 цаг:  
Босож суух



**ДЭМБ ЗӨАБ**-ийн IMAI дүүргийн эмнэл зүйн гарын авлаган дээр үндэслэв